**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 11 өдөр | Дугаар А/722 | Булган сум

Гадаадад албан хэргээр
ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Онцгой байдлын газрын Тасгийн дарга Д.Ууганбаяр, Статистикийн хэлтсийн дарга М.Мөнхбат, Солонгос Улс дахь Булган аймгийн төлөөлөгч Х.Насанбат нарыг 2023 оны 10 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад албан томилолтоор ажиллуулсугай.

2. Албан хэргээр ажиллах болсонтой холбогдуулан Гадаад харилцааны яамны Консулын газраас дээрх албан хаагчид гадаад албан пасспорт хүссүгэй.

3. Албан хаагчийн гадаад албан пасспортын хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

832301/815